



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2022 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 53

Мандалговь

С.Ганбаярыг Мал эмнэлгийн газрын Өлзийт  
сумын Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагчийн  
албан тушаалд нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2022 оны 5 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


Нэг. Аймгийн Мал эмнэлгийн газрын Өлзийт сумын Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Сарнайн Ганбаяр 60.0 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа С.Ганбаярын холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ



Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь  
салбар зөвлөлийн 2022 оны ...~~4~~... дугаар сарын  
...~~21~~...-ны өдрийн ...~~33~~... дугаар тогтоолын хавсралт



**Мал эмнэлгийн газрын Өлзийт сумын Мал эмнэлгийн  
тасгийн улсын байцаагчийн албан тушаалд нэр дэвшүүлсэн  
С.Ганбаярын тухай дүгнэлт**

1. С.Ганбаяр нь 1996 онд Дундговь аймгийн Өлзийт суманд төрсөн. 26 настай, эрэгтэй
2. Боловсрол: 2013-2018 онд Хөдөө аж ахуйн их сургуулийг Малын их эмч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. С.Ганбаярын тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Мал эмнэлгийн газрын Өлзийт сумын Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагчийн албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ**